



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/446

Зуунмод

Хоршоологчдын улсын зөвлөгөөн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 65 дугаар зүйлийн 65.1.1, Засгийн газрын 2012 оны 95 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 95 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хоршоологчдын улсын зөвлөгөөн”-ийг Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоотой хамтран 2019 оны 08 дугаар сарын 04-нөөс 07-ны өдрүүдэд Эрдэнэ суманд зохион байгуулсугай.

2. Улсын хоршоологчдын зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Зөвлөгөөнд шаардагдах 3.356.200/Гурван сая гурван зуун тавин зургаан мянга хоёр зуун/ төгрөгийг аймгийн хуваарилагдаагүй зардлаас гарган санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ю.Бямбацогт/-т зөвшөөрсүгэй.

4. Төлөвлөгдсөн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчилж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Н.Мөнхсайхан/-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Д.Мөнхбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2019 оны
08 дугаар сарын 02 -ний өдрийн
АМЖ дугаар захирамжийн 2 дугаар хавсралт.

**ХОРШООЛОГЧДЫН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨНИЙ
ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Зочид төлөөлөгч нарт гарын бэлэг -УИХ-ын гишүүн, МХААХҮХолбоо-2 -ХХААХҮЯам-2 -21 аймаг, нийслэл-22 -ОУБайгууллага-2	28 хүн	40.000	980.000 төг
2	Анонс 9х5.3, “Төв аймагт тавтай морил” урт хаяг 15*1	62.7 м ²	6.000	376.200 төг
3	Хүндэтгэлийн арга хэмжээ	250	8000	2.000.000 төг
	НИЙТ ДҮН		3.356.200 төг	

Төсөвлөсөн:
ХХААГ-ЫН АЛБАҢЫ ДАРГА

А.ТУЯАЖАРГАЛ

Хянасан:
СТСХ-ийн ахлах мэргэжилтэн

Ч.ЦЭЦЭГСҮРЭН